

**БАТЛАВ.**  
**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН**  
**ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН**  
**ДАРГА**

**БАТЛАВ.**  
**МОНГОЛ УЛСЫН САЙД, 20 МИНУТЫН**  
**ХОТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА**

**Н.УЧРАЛ**

**Р.ЭРДЭНЭБҮРЭН**

**БАТЛАВ.**  
**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН**  
**СУУЦЖУУЛАЛТЫН САЙД**

**БАТЛАВ.**  
**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН**  
**САЙД**

**Ж.БАТСУУРЬ**

**О.АЛТАНГЭРЭЛ**

## **ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ** **ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Нийслэл хот нь дагуул хоттой байна.” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “Нийслэл хотын дагуул хот /цаашид "дагуул хот" гэх/ нь нийслэл хоттой эдэлбэр газар, хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, тээвэр, логистикийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, газар зүйн байрлал болон нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдолтой, хот бүрдүүлэгч дэд бүтэц бүхий төвлөрсөн суурин газар мөн.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 9.5-д “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.” гэж заасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Хууль санаачлагч тодорхой хууль санаачлах бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хүрээ, хязгаарт нийцүүлэн, хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.” гэж, 15.4 дэх хэсэгт “Хууль тогтоомжоор зохицуулах нийгмийн харилцаа нь Засгийн газрын хэд хэдэн гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байвал хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэсэн зохицуулалтыг нэмсэн бөгөөд энэ зохицуулалтын хүрээнд өнөөгийн аймгийн төвүүд буюу засаг захиргааны нэгж дэх улсын зэрэглэлтэй хотууд бие даан хөгжих эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн энэ өөрчлөлтийг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор органик хууль буюу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан. Тодруулбал, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ орон нутгийн эдийн засгийн бүтэц, чадавх, хүн амын болон газар зүйн байршил, дэд бүтэц, тэдгээртэй холбогдох бусад нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.” гэж, 68.3 дахь хэсэгт “Хотын зэрэглэл, тосгоны онцлогийг харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлж болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хязгаарлалт тогтоож болно.” гэж тус тус заасан.

## 1.2. Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай” анхдагч хуулийг баталж, мөн өдөр “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 76 дугаар тогтоолоор “Шинэ Зуунмод хот”-ыг нийслэлийн тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдол бүхий Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байхаар заасан.

Шинэ Зуунмод хот нь хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, эдийн засагтай, нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэх, Төв аймагтай бүх талаар хөгжлийн интеграцид орж хотын эдийн засгийн үр ашгийг хамт хүртэх нөхцөл боломжийг бүрдүүлэх хүрээнд бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх шатанд шийдвэрлэх шаардлагатай тодорхой нөхцөл тулгараад байна.

Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын төслийн явц, үр дүнгийн зах зээл, эдийн засаг, нийгмийн хэрэгцээ, олон улсын хэмжээнд оруулах хувь нэмрийг тодорхойлж, олон улсын хөрөнгө оруулагчдыг татах, түншлэл, дэмжлэгийг нэмэгдүүлэхэд хотыг дүр төрхийг тодорхойлох, түүх, соёл, байгаль орчин, эдийн

засгийн чадамж гэх мэт бусдаас ялгарах онцлог болон хотын хөгжлийн зорилго, ирээдүйн байр суурийг төлөөлөхүйц нэр шаардлагатай болох нь харагдаж байна.

Дотоодод буюу Монгол Улсын хэмжээнд Шинэ Зуунмод хот гэх нэршил Төв аймаг буюу Зуунмод хотын дагуул хот гэх зөрүү ойлголтыг төрүүлж байгаа талаар хуулийг хэрэгжүүлж эхэлсэн өнгөрсөн хугацаанд багагүй гарсаар байна. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Хот байгуулах тухай” 72 дугаар тогтоолыг баталсан бөгөөд тус тогтоолд Төв аймгийн засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгжид улсын зэрэглэлтэй Зуун мод хотыг байгуулах тухай шийдвэрлэсэн юм.

Мөн олон улсын түвшинд хөрөнгө оруулалт татах тохиромжтой төсөл болохыг танилцуулах, цаашид олон улсад танигдсан хот болоход тохирохуйц, Монгол Улсын талаарх төсөөллийг бий болгох болон олон улсын санхүү, бизнес, аялал жуулчлалын төв, ухаалаг хот байх нөхцөлийг илэрхийлэх нэршлийг тогтож, төсөл танилцуулах үе шатнаас хотын нэрийг хоногшуулах нь чухал байна.

Хотын нэрийг олон улсад дуудах, бичихэд хялбар, ойлгомжтой болгож, Монгол Улсын талаар төсөөллийг бий болгох, илэрхийлж чадах нэршилтэй болгосноор олон улсад брэндиг хийх нөхцөл бүрдэх, түүнчлэн хотын нэрийг соёлын өв, түүхийг онцолж, судалгаанд үндэслэн маркетинг, сурталчилгааны стратегийг төлөвлөх ач холбогдолтой юм.

Монголчууд эртнээс төрт ёсны түүхтэй, Еврази төдийгүй дэлхий дахинд нэр алдар нь түгсэн эзэнт гүрнүүдийн өлгий нутаг билээ. НТӨ I мянганд Евразийн хээр талд нүүдлийн иргэншил давамгайлан хөгжснөөр, Хүннү нар төв азийн тал нутагт төрийн зохион байгуулалттай хүчирхэг нүүдэлчдийн төрт улсыг үүсгэн, олон улсын худалдаа-торгоны замыг хяналтдаа авч, Европ, Азийн түүхэнд гүнзгий ул мөр үлдээсэн.

Тиймээс олон улсын түвшинд шинэ хотыг илэрхийлэн таниулах, Монгол Улсын талаар төдийгүй шинэ хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, төслийн зорилтыг илэрхийлж чадах нэрийг “ХҮННҮ ХОТ” гэж тодорхойлж байна.

ХҮННҮ ХОТ болсноор Хүннү Улсыг англиар "**Xiongnu Empire**" гэж бичдэг байдлыг өөрчлөн HUNNU гэх монгол дуудлагыг таниулах, хоногшуулах хэрэгцээ үүснэ. Хүннү гэх нэр нь Хүннүгийн түүхэн эх сурвалжид дурдагдсан хэлбэр болох "Xiongnu" (Шиунну гэж дуудагддаг)-аас гаралтай бичигдсэн нь уламжлагдан ирсэн бөгөөд **Hunnu Empire** бичиглэлийг олон улсад хэвшүүлэх хэрэгцээ үүснэ.

“Шинэ зуун мод” хотын ирээдүйн төлөвлөлт, чиг хандлага нь орчин үеийн дэвшилтэт, өндөр технологид суурилсан, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9-д Нийслэл Улаанбаатар хот, түүний дагуул хотыг “Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлэх” зорилгыг агуулсан “УХААЛАГ ХОТ” гэсэн үзэл баримтлалын хүрээнд нийцүүлэн “ХҮННҮ ХОТ” гэж нэрлэх нь уламжлал, шинэчлэлийг хослуулсан томъёолол гэж үзлээ.

## **Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна. Хуулийн төсөл нь гурван зүйлтэй байх бөгөөд нэгдүгээр зүйлд “Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай” хуулийн нэрийг “Хүннү хот” болгон өөрчлөх болон хууль доторх эшлэл авсан зохицуулалтыг өөрчлөх, хоёрдугаар зүйлд хууль хоорондын зөрчлийг арилгах зорилгоор мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8 дахь заалтыг хүчингүй болсонд тооцох, гуравдугаар зүйлд хуулийн төслийн дагаж мөрдөх хугацааг зохицуулахаар тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

“Шинэ Зуунмод” хотыг “Хүннү” ухаалаг хот болгон өөрчилснөөр дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар гарна гэж үзэж байна. Үүнд:

- Шинэ хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлнэ;

- “Хүннү” ухаалаг хот байгуулах төслийн агуулга, ач холбогдлыг тодорхой болгож, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад нэр томъёоны хувьд төөрөгдөл үүсгэхгүй төдийгүй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ;

- Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлж, өнөөгийн төдийгүй ирээдүйн хэрэгцээг хангахын зэрэгцээ байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг дэмждэг амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, ухаалаг хот болгон хөгжүүлэх нөхцөлийг хангана;

- Шинэ Зуунмод хотын захирагч чөлөөт бүсийн захирагчийн чиг үүргийг давхар хэрэгжүүлэхээр Чөлөөт бүсийн тухай хуультай зөрчилдсөн зохицуулалтыг хүчингүй болгосноор хууль хоорондын зөрчил арилна.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---o0o---